

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн



АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний аудитын газар 2018

Агуулга

I.Аудитын нэр.....	2
II.Аудитын код.....	2
III.Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	2
IV.Аудитын зорилтууд.....	2
V.Аудитын хамрах хүрээ.....	2-
VI.Байгууллагын эрхэлдэг үйл ажиллагааны чиглэл, харьяалал.....	3
VII.Эрсдэлийн үнэлгээ.....	4
VIII.Аудитын арга зүй.....	5
IX.Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд.....	5
X.Аудит хийх багийн бүрэлдэхүүн.....	5
XI.Аудитын хугацаа.....	6
XII.Аудитын хөтөлбөр.....	6
XIII.Аудитын үр өгөөжийн тооцоолол.....	6
XIV.Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам.....	6
XV.Аудитад шаардагдах хөрөнгө нөөц.....	6
XVI.Хавсралтууд.....	
XVII.Судалгааны маягтууд.....	

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Д.ХҮРЭЛБААТАР
2018 оны 2-р сарын 05 өдөр

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

I. Аудитын нэр

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд хийх аудит.

II. Аудитын код: /САГ-2018-03-CA/

III. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын А/06 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газрын 2018 онд аудит хийх төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

IV. Аудитын зорилтууд:

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

1. Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх
2. Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

V. Аудитын хамрах хүрээ:

Аудитыг Төрийн сангийн 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан гүйцэтгэх бөгөөд Төв төрийн сан, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, зарим төрийн байгууллагууд хамрагдана.

VI. Байгууллагын эрхэлдэг үйл ажиллагааны чиглэл, харьяалал:

Сангийн яамны Төрийн сангийн газар 1993 онд байгуулагдаж, 1998 онд Төсвийн бодлогын газрын харьяанд Төрийн сангийн хэлтэс, 1999 онд дахин Төрийн сангийн газар болон зохион байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд Засгийн газрын дараах тогтоолуудаар шилжиж байжээ. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан банк, санхүүгийн салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх зорилгын хүрээнд Засгийн газрын 2001 оны 125 дугаар тогтоолоор “Санхүүгийн салбарын шинэчлэлийн дунд хугацааны үзэл баримтлал”-ын 2.1.3-т төсвийн санхүүжилтийн гүйлгээг зохицуулах, бүртгэл хийх, тайлан гаргах үүрэг бүхий Төрийн сангийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, шилжүүлэх үйл явцыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр заасан байна.
- Засгийн газрын “Төрийн сангийн тогтолцоонд шилжих тухай” 2002 оны 101 дүгээр тогтоолоор Монгол Улсын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн албаны бүтцийг төрийн сангийн тогтолцоонд шилжүүлсэн байна.
- Засгийн газрын 2002 оны 272 дугаар тогтоолоор Төрийн сангийн нэгдсэн дансны тогтолцоонд агентлагууд, Засгийн газрын тусгай зориулалтын сангууд болон өөрийн орлоготой байгууллагууд, Нийгмийн даатгалын сангуудыг хамруулсан. Мөн Нийслэл, дүүргүүдийн төрийн сангийн хэлтсийн харилцах дансыг Монголбанк дахь Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах асуудлыг ОУВС-тай зөвшилцөн шийдвэрлэх гэсний дагуу арилжааны банкинд байршиж байсан төсөвт байгууллагуудын харилцах дансны үлдэгдлийг төрийн сангийн бүртгэлийн дансанд шилжүүлэн байршуулж, төрийн сангийн газраас төлбөр тооцооны үйлчилгээг үзүүлж эхэлжээ.

Мөн Төсвийн тухай хуулийн 4, 36, 37 дугаар зүйлд Төрийн сантай холбоотой нийтлэг чиг үүрэг, төв төрийн сангийн чиг үүргүүдийг хуульчилсан байна.

Төв төрийн сангаас гадна 21 аймаг, 9 дүүрэг, 330 сумдад төрийн сангийн хэлтэс, төрийн захиргааны төв байгууллагын 13 нэгжид нийт 1800 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

Төрийн сангийн газар нь:

1. Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтэс
 - Төсвийн хуулийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг санхүүжүүлэх, бүртгэл хөтлөх
 - Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг боловсруулах, тайлагнах
2. Төлбөр тооцооны хэлтэс
 - Улсын төсөв болон төсвийн захирагчдын төлбөр, тооцоог зохих дүрэм, журмын дагуу шуурхай хийж гүйцэтгэх
 - Төрийн сангийн төлбөр тооцооны мэдээллийн системийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймаг, сум, дүүргийн төрийн сангийн орон тоог тухайн шатны Засаг даргын захирамжаар баталж байна.

Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжсэнээр зардлыг зүйл ангиар бүлэглэн зарцуулах зарцуулалтад тавих хяналт сайжирч, мөнгөн хөрөнгийг үр дүнтэй удирдах боломжтой болсон байна.

VII. Эрсдэлийн үнэлгээ

Аудитын ерөнхий эрсдэлийг төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, урьдчилсан дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн “ДУНД” гэж үнэлсэн. (Эрсдэлийн үнэлгээг хавсралт №1-т үзүүлэв)

VIII. Аудитын арга зүй

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан гүйцэтгэлийн аудитын журмын дагуу Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авч бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн зорилтот арга хэмжээнээс түүвэрлэн горим, сорил хэрэгжүүлнэ.

Мөн аудитын асуудлын шинжилгээ, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйлс цуглуулан (Асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт №2, 3-т үзүүлэв) аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

IX. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль, тогтоомжийг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

Хуулиуд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Өрийн удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хуулиуд.

Засгийн газрын тогтоол:

- Төрийн сангийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх тухай-2013
- Санхүүгийн алба байгуулах тухай-2014
- Төрийн сангийн үйл ажиллагааны журам-2015

Сангийн сайдын тушаал:

- Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам-2012
- Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам-2012
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх, Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам-2013
- Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монголбанк, арилжааны банкинд нээх, хаах журам-2013
- Төрийн сангийн нэгдсэн дансны чөлөөт эх үүсвэрийг удирдах журам-2014

- Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам-2014
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам-2014
- Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн төлөвлөлтийн журам-2014
- Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар-2015
- Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам-2016
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам болон бусад холбогдох хууль, журмуудыг ашиглана-2017

X. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, Я.Самбууням нар хэрэгжүүлж, I,III дугаар албаны ахлах аудитор, аудитор нар хийж гүйцэтгэнэ.

Мөн Аймаг нийслэлийн төрийн сангийн хэлтэс, нэгжийн үйл ажиллагаанд хийх аудитыг аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагын дарга бөгөөд тэргүүлэх аудиторуд удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежерүүд хэрэгжүүлж, ахлах аудитор, аудиторуд гүйцэтгэн аудитын тайлан болон судалгааг төлөвлөгөө хөтөлбөрт заасан хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

XI.Аудитын хугацаа:

Аудитын төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатны ажлыг 2018 оны 6 дугаар сарын 2-ноос, талбарын ажлыг 6 дугаар сарын 25-наас, тайлагналын үе шатны ажлыг 11 дүгээр сарын 05-наас тус тус эхлэх ба нэгдсэн тайланг 12 дугаар сарын 03-ны дотор хийж, чанарын хяналт, баталгаажуулалт хийлгүүлэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагууд 2018 оны 11 дүгээр сарын 05-ны дотор аудитын тайланг цахимаар болон албан бичгээр ирүүлнэ.

XII.Аудитын хөтөлбөр:

Аудитын хөтөлбөрийг төлөвлөгөөний (хавсралт №4)-т үзүүлэв.

XIII.Аудитын үр өгөөжийн тооцоолол:

Үр өгөөжийн тооцооллыг УАГ-1110 маягтаар төлөвлөн хавсралт №5-д үзүүлэв.

XIV.Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал түүнд өгсөн тайлбар гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг аудитын дэд зорилт тус бүрээр бичнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авах бөгөөд тайлангийн эцсийн хувилбарыг Үндэсний аудитын газрын Аудитын зөвлөл болон Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулна.

XV.Аудитад шаардагдах хөрөнгө нөөц:

1. Хүний нөөц ахлах аудитор, аудитор:
 - Үндэсний аудитын газар - 14
 - Нийслэл дэх төрийн аудитын байгууллага – 19
 - Аймгууд дахь төрийн аудитын байгууллага – 73 нийт 106
2. Санхүүгийн нөөц:
 - Сарын дундаж цалин, нийгмийн даатгалын шимтгэл 1.3 сая төгрөг, 106 ахлах аудитор болон аудитор нийт 498.9 сая төгрөг
 - Дотоод албан томилолт 92 ахлах аудитор, аудитор дундажаар 5.5 хоног нийт 61.7 сая төгрөг,
 - Зөвлөх, нарийн мэргэжлийн гэрээт ажилтны зардал 9.0 сая, нийт 569.6 сая төгрөг зарцуулна.
3. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, принтер, видео камер, зургийн аппарат, дуу хураагуур болон бусад техник хэрэгсэл

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ:

ХЯНАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ОЮУНБИЛЭГ

БОЛОВСРУУЛСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ГҮНЖИДМАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

Г.ЖАВХЛАН

АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

АУДИТОР

П.АМАРСАНАА

Огноо: 2018.06.19